

**“АРД ТҮМНИЙ ОЛОНХИЙН ЗАСАГЛАЛ”
НАМЫН УИХ-ЫН 2020 ОНЫ СОНГУУЛИЙН
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**


“АРД ТҮМНИЙ ОЛОНХИЙН ЗАСАГЛАЛ” Нам нь Монгол Улсын үндэсний язгуур эрх ашиг, тусгаар тогтнол, ардчилал хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг эрхэмлэн баялаг бүтээгч, орчин үеийн нийгмийг цогцлоох зорилготой хамтач, эх оронч, үндэсний үзэл санаатай, нийгмийн ардчиллын үзэлд суурилсан зүүн төвийн нам юм. АТОЗ НАМЫН эрхэм зорилго нь улс эх орноо хөгжил дэвшилд иргэдээ сайн сайхан амар амгалан аз жаргалтай амьдралд хүргэх явдал билээ.

Нэг: Үндэсний үзэл санааны хувьсгал

1. Монгол Улс Монголын ард түмний язгуур эрх ашгийг хамгаас эрхэмлэн дээдэлнэ
2. Хүүхэд залуучууд, нийт иргэдийг хамарсан эх түүх, эх хэл, бичиг, эх орноороо бахархан дээдлэх ёс суртахууныг төлөвшүүлэх “ Ёс суртахуунтай Монгол иргэн” үндэсний хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бий болгоно.
3. Нийгмийн хөгжлийн хамгийн том саад болсон авлигыг устгаж, нийгэмд авлигыг, авлигачдыг үл тэвчих сэтгэлгээг суулгаж авлигын эсрэг тэмцлийг үе шаттай өрнүүлж хууль эрх зүйн орчныг сайжруулна.
4. Хамтач, хөдөлмөрч, бүтээлч хандлагыг иргэдэд төлөвшүүлж, хариуцлага, сахилга бат, дэг журам, шударга ёс, хуульт ёс, хяналт бүхий иргэддээ тэгш боломж олгодог орчин үеийн нийгмийг байгуулах хууль эрх зүйн орчныг бий болгоно.
5. Түүх соёл, гүн ухаан ёс заншил, уламжлал үндэсний үнэт зүйлсээ дээдэлсэн эх оронч нэгдмэл үндэсний үзэл санаатай иргэдийг төлөвшүүлэх соён гэгээрлийн, үйл ажиллагааг зохион байгуулж ажиллана.
6. Боловсролын системд үндэсний түүх, хэл, соёл, уламжлалаараа хойч үеэ сурган хүмүүжүүлэхэд онцгой анхаардаг болгох, үндэсний боловсон хүчнийг хэрэгцээ шаардлагадаа тохирсон хэмжээнд бэлтгэх бодлого боловсруулна.
7. Дэлхийн Монгол угсаатнууд хэл ,соёл, уламжлалаараа нэгдэн нийтлэг болохыг дэмжинэ.

Хоёр: Шударга ёсны хувьсгал

1. Төрд бугшсан шударга бусын тогтолцоог халж, тэгш эрх, тэгш боломжийг бий болгохын төлөө бодлого боловсруулж, бүх яам, агентлаг, нийслэл, дүүрэг, аймаг сумдад иргэдийн хяналтын зөвлөл байгуулж ажиллах хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхийн төлөө ажиллана.
2. Бүх шатны засаг дарга нарыг иргэд сонгох эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
3. Бүх шатны шүүгч, прокурор, АТГ – ын удирдлагыг томилоход иргэдийн саналыг харгалзан үздэг тогтолцоог бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
4. Засгийн Газрын бүтцэд Аж үйлдвэрийн болон Үндэсний Бодлого Төлөвлөлтийн яамыг заавал байгуулж, шинжлэх ухааны нарийвчилсан судалгаа, шинжилгээ, хөгжлийн бодлого төлөвлөлтийг төрийн үйл ажиллагааны суурь зарчим болгож мөрдүүлэх эрх зүйн орчинг бий болгоно.
5. Хууль хяналтын байгууллагад ард иргэд хяналт тавих эрх зүйн орчинг бүрдүүлэн, эрүүл зөв хяналтыг тогтолцоог бий болгоно.
6. Прокурор, Шүүх, Цагдаагийн байгууллагын удирдлагыг нийт бүрэлдэхүүнээс сонгосон хараат бус зөвлөлөөс сонгож баталдаг тогтолцоонд шилжүүлэх хууль эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
7. Ард нийтийн сонгуулийг зохион байгуулдаг, Сонгуулийн Ерөнхий Хороонд улс төрийн намуудаас болон нам бус иргэдийн төлөөллийг тэгш эрхтэй оролцуулах хууль эрх зүйн орчинг бүрдүүлнэ.



8. Нийтийн баялгаас хууль бусаар хөрөнгөжсөн этгээдүүдэд хатуу хариуцлага тооцож, хууль бус хөрөнгийг хурааж улсын орлого болгох хууль эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
9. Төрийн үйлчилгээг ухаалаг, цомхон, шуурхай цахим болгож, илүү зардлыг багасгаж хүний төлөө хүндээ хүндэтгэлтэй ханддаг төрийн албатай болгоход хуулийн орчинг бий болгоно.
10. Төрийн албан хаагчдыг мэргэжлийн салбарт ажиллуулахдаа дээрээс шууд томилдог босоо тогтолцоог өөрчилж, төр засгийн дунд, доод шатны байгууллагуудад ажил мэргэжил албан тушаал, ажиласан жил, туршлага, гавъяа зүтгэлийг нь харгалзан үзэж томилдог байсан итгэл үнэмшлийн зарчмыг сэргээх хууль эрх зүйн орчинг бий болгоно.

Гурав: Аж үйлдвэржилт эдийн засгийн хувьсгал

1. Үндэсний эдийн засгийн тусгаар тогтнол, аюулгүй байдлыг бий болгоход чиглэсэн шат дараатай цогц арга хэмжээг хэрэгжүүлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгоно.
2. Харь орнуудын түүхий эд бэлтгэн баялгаа боловсруулалгүй экспортлодог эдийн засгийнсул дорой тогтолцооноос улс орноо салгах хууль эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
3. Оюун ухаан мэдлэг, шинжлэх ухаанд суурилсан, олон тулгуурт холимог эдийн засгийн бүтцийг бий болгож, үр өгөөжийг нь нийт иргэд тэгш хүртдэг, баялаг бүтээгч иргэд эдийн засгийн тэгш боломжтой болох хууль эрх зүй, эдийн засгийн орчныг бүрдүүлнэ.
4. Хөдөө аж ахуй, аялал жуулчлал, инноваци цахим технологи, орчин үеийн үйлдвэрлэлийн салбарыг тууштай хөгжүүлэх алсын хараатай бодлого бий болгоход хувь нэмрээ оруулна.
5. Төсөв, санхүү, банкны бодлогод өөрчлөлт хийж. Төсвийн хөрөнгийн зарцуулалтыг ил тод нээлттэй болгох. Төсвийн хэмнэлтийн бодлого барьж, өр зээлийн урхинд орох эрсдлээс хамгаалах хууль эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
6. Засгийн Газраас явуулж байгаа төсвийн бодлого, зарцуулалтанд иргэд хяналт тавих эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
7. УИХ-аас татварын бодлогод сөргөөр нөлөөлөх эрх ашгийн зөрчилтэй хууль санаачлахыг хориглоно. УИХ болон ЗГ-ын гишүүд хараат бус ажиллах хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын хоорондын хамаарлыг арилгах эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
8. Жижиг, дунд үйлдвэрүүдийг татварын болон хөнгөлөлттэй зээл тусламжийн бодлогоор дэмжиж, дотоодын зах зээлээ хамгаалах, үндэсний үйлдвэрлэгчид, баялаг бүтээгчдээ дэмжих эх оронч худалдан авалт хийх үйл ажиллагааг төрийн бодлогын түвшинд явуулах эрх зүйн орчинг сайжруулна.
9. Ард иргэдээ өндөр хүүтэй банкны зээлийн дарамтаас салгах, “Өрийн дарамтгүй иргэн” үндэсний хөтөлбөр хэрэгжүүлж, баялаг бүтээж амьдрах нөхцөл бололцоогоор хангах эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
10. Үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшийг чангаруулах, худалдан авах чадварыг сайжруулах бодлого барих эрх зүйн орчинг бий болгоно.
11. Үндэсний эдийн засаг дахь төрийн хувийг нэмэгдүүлж, төрийн өмчийг үнэгүйдүүлсэн алдаа завхралтыг арилгана. Зориулалтын бусаар ашигласан үйлдвэрийн газруудын хувьчлалыг цуцалж хохирлыг нөхөн төлүүлнэ.
12. Архи, согтууруулах ундаа, тамхи гэх мэт хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импортод өндөр татвар оногдуулах замаар хязгаарлах эрх зүйн орчинг сайжруулна.
13. Үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэлхийн түвшинд хүргэх. Дотоодын хөрөнгө оруулагчдыг дэмжинэ. Иргэд хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагаанд чөлөөтэй оролцдог орчин үеийн системийг нэвтрүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.



10

9006109
01912035

14. Ипотекийн зээлийн хүүг хамгийн бага түвшинд хүргэж, “Ард түмний орон сууц” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
15. Монгол Улсын улс төр, эдийн засагт ноёрхсон неолиберал үзэл санааг халж, иргэн бүрт үр өгөөжөө өгдөг нийгмийн баялгийн тэгш хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлэх эдийн засгийн орчинг бий болгоно.
16. Эдийн засгийн хөгжлийн бодлого төлөвлөлтийг бодитойгоор бий болгож, богино, дунд, урт хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлтийн стратегийг судлаач, эрдэмтдийн оролцоотой бий болгоход хувь нэмрээ оруулна.
17. Иргэн бүрт баялаг бүтээх үйлдвэрлэл эрхлэхэд нь тусалжүйл ажиллагааг нь дэмжих банк байгуулах. Үйлдвэрлэл эрхлэх санаачлагыг бүх талаар бодитой дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

АРД ТҮМНИЙ ОЛОНХИЙН ЗАСАГЛАЛ НАМ

Намын дарга:  /Ц.НАРАНГЭРЭЛ/
Ерөнхий нарийн бичгийн дарга:  /П.ДАВААСАМБУУ/



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.04.21 № 1180
танай _____-ны № _____-т

АРД ТҮМНИЙ ОЛОНХИЙН
ЗАСАГЛАЛ НАМД

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.17, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох “Ард түмний олонхийн засаглал нам”-аас ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүнгийн хамт Төрийн аудитын байгууллагад ирүүлж, Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5-д заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Үндэсний аудитын газар нь Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ “Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020” Тулгуур зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020” Нийцлийн аудитын зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020” Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

“Ард түмний олонхийн засаглал нам”-ын Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3. дахь хэсэг, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

“Ард түмний олонхийн засаглал нам”-ын мөрийн хөтөлбөр /...³... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Сонгуулийн Ерөнхий хороонд

Д.ЗАНДАНБАТ